

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Найнаа	Дугаар	L184
Оршин суугаа аймаг	Говь-Алтай	Оршин суугаа сум	Шарга
Төрсөн газар	Шарга сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Алаг-Өндөрийн хүрээ	Сүм хийдийн дугаар	ГАНР 106
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 27	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан

Говь-Алтай аймгийн Шарга сумын Алаг-Өндөрийн хүрээ

Асуулт:-Та бидэнд Сүжигт бэйсийн хүрээний тухай ярьж өгнө үү.Сүжигт бэйсийн хүрээ гэдэг нь хаана байсан юм бэ?

Хариулт:-Дунд шарын голд

Асуулт:-Хэд орчим ламтай байсан юм бол?

Хариулт:-Манай хуучин сумын төв дээдэх юун дээр чинь бас Аливаа да лам гэж байсан. Жаахан **Алиадай** лам гээд хоёр ланжгар лам хоёр хүрээтэй, хоёр дугантай, нэлээн олон жижиг лам нар байсан. Одоо ч гэсэн тэр дээр бас Шар яамны хамгийн том хүрээ нь тэр л дээ. Алаг Өндөрийн хүрээ.

Асуулт:-Алаг Өндөрийн хүрээний том ламыг нь мэдэх үү, хэн гэдэг хүн байсан бэ?

Хариулт:-Баян Бадарч гэдэг хүний ах болох Аливаа да лам гэж байсан юм. Жаахан **Алиадай** лам гэдэг нь энд байж байгаад аймаг дээр очоод үхчих шиг болсон. Хоёр ийм том лам, хоёр их том хүрээ энд байсан юм. Сүүлдээ сайн лам, ёстой өнөөх хүний **хойтохыг** уншдаг том лам хаана байв манай энд байлаа.

Асуулт:-Алаг Өндөрийн хүрээ гэдэг нь цаад талдаа байдаг юмуу?

Хариулт:-Алаг Өндөрийн хүрээ чинь дээдэх яг манай Алаг Өндөр гэдэг ардаасаа босготой хавтгай уул байдаг юм. Урдаасаа болохоор чанх хүн гарч ирдэггүй, мал гарч ирэхгүй ийм Алаг Өндөрийн хайрхан гэдэг тийм хайрхан уул байгаа юм.

Асуулт:-Тэр Алаг Өндөрийн хүрээний лам нар уул хангайгаа тахидаг байсан үү? ямар уул тахидаг байсан бэ?

Хариулт:- Урд голын овоо гэдэг чинь бүр нэртэй, их том овоо байдаг юм. Адуугаа тавиад **тэнд** дээр очиж барьдаг, яг энэ урд шувтрах үзүүр байна шүү дээ.

Асуулт:-Урд голын овоо гэдгийг тахидаг байсан юмуу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Тэрнийг тахидаг байсан юм.

Асуулт:-Алаг Өндөрийн хүрээний лам нар уу?

Хариулт:-Хаанаас ч гэсэн тахидаг байсан. Том том лам нар чинь өдөр судраа хараад тэгээд **овоогоо** тахиад янз янз болно л доо.

Асуулт:-Бөх барилдаж, морь уралддаг байсан уу?

Хариулт:-Яриа байхгүй. Бөх барилдана, морь уралдана, Шуухнаа дарга гэж тариа ногоог тарьдаг хүн мэдэж тэрнийг ёстой санасандаа, амьтан болгоноос, айл болгоноос борлон, шүдлэн, даага, 5, 10 цаас, янз янзын юм цуглаад тэгээд их өргөнөөр тахиж байсан юм.

Асуулт:-Жилд 1 удаа тахиж байсан уу?

Хариулт:-Нэг удаа тахиж байсан. Тэгээд уруудаад доод талын манай Шаргын урд талд Загийн овоо. Рашаантын эх чинь хамгийн том овоо тэр байсан юм. Тэрнээс цаашлаад хуучин 6-р баг гэж байсан.

Асуулт:-Энэ овоонуудыг цагаан идээгээр тахидаг байсан юмуу? Шүүсээр тахидаг байсан юмуу?

Хариулт:-Юм болгоноор. Хонь малаа ч гаргана, сүү, **тарагныхаа** дээжийг өргөж барьж тэр овоон дээр өргөж сайхан байхгүй юу.

Асуулт:-Алаг Өндөрийн хүрээний гол шүтдэг бурхан нь ямар бурхан байсан юм бол? Гол шүтээн нь.

Хариулт:-Ямар юм байлаа.

Асуулт:-Тэр хүрээн дээр **Ганжуур, Данжуур** гээд том судрууд байсан уу?

Хариулт:-Байсан. Тэр байтугай манай Шаргын төв дээр **Жихээ** дацан гээд энэ дор яг хүрээ байсан. **Тэрэн** дээр чинь судартай.

Асуулт:-Алаг Өндөрийн хүрээнд Майдар гаргадаг байсан гэсэн үү? Тэрний тухай та ярьж өгөхгүй юу? Хэдэн настай байхдаа үзэж байсан бэ?

Хариулт:-Би цэрэгт яваад 2, 3 дайнд ороод алаг морьтой Дандар, алдартай хүмүүстэй чинь 2 дайнд орчихсон, миний одон медаль янз янзын юмны тухай би Японы Хайлааст манханд 5 жил 6 сар болоод цэргээс халагдаж ирсэн. Тэгтэл миний ээж миний ингэж удаж байхад үхчихсэн байлгүй, яалаа гэж ингэж удаан амьд явж байдаг байв гэж бодож байсан юм.

Асуулт:-Майдарын тухай ярьж өгөхгүй юу?

Хариулт:-Майдар бол их л том хамгийн их чадалтай, чинээтэй тийм улсууд **Майдар** номоо эргэж, овоогоо тахиж, яриа хөөрөөгөө нэгтгэж аль овоог тахивал явал таарах нь вэ, тэрнийг тахисан одоо алиныг тахивал таарах вэ гээд.

Асуулт:-**Жод лүйжин** тавьдаг лам нар байсан уу?

Хариулт:-Миний аав ээжийн үед л лав, миний мэдээ ороход л Алаг Өндөрийн хүрээ гэж бүр нэртэй, **Майдар** эргэдэг.

Асуулт:-100 гаруй ламтай байсан гэл үү?

Хариулт:-100 гаруй лам байлгүй **яхав**.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Та тэр хүрээний барилга байшингийн тухай ярьж өгөхгүй юу? Юугаар барьсан байсан юм бол?

Хариулт:-Тэр баримлыг голдуу түйпуу, чулуу, тийм юмаар голдуу барьсан л даа.

Асуулт:-Монгол мужаанууд барьсан уу?

Хариулт:-Монгол улс.

Асуулт:-Тэр үед хятадын **худалдаачид** явдаг байсан уу? энүүгээр.

Хариулт:-Яриа байхгүй.

Асуулт:-**Гүн ламын** хүрээ гэж хаана байсан юм бол?

Хариулт:-Харин тэр хүрээ чинь энэ **дээдэхийг** хэлээд байна шүү дээ. Манай хуучин сүмийн төв.